

Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

Монгол улсын их сургууль байгуулагдсан түүхээс

Доктор /Ph/, профессор З.Баасанжав /МУИС/

Эрдэм ухааныг эрхэмлэн дээдлэж ирсэн баялаг уламжлалтай монголчуудын боловсролын түүхэнд дээд боловсролын байгууллага одоогоос 700 гаруй жилийн тэртээгээс үүсэн бий болсныг буурал түүхийн хуудас гэрчлэх авай.

Эл үе нь монголчууд дэлхийн түүхийн тавцнаа гарч манай гарагийн бараг ихэнхийг өөрийн дээвэр дор нэгтгэн, бусад улс түмнүүдэд нүүдлийн соёл иргэншлийн амьдрах чадвартай шинжүүдийг түгээн дэлгэрүүлж, тэднээс ч бас чамгүй зүйлийг өвлөн авч, нүүдлийн хийгээд суурьшмал иргэншлийн хөгжлийн хэлхээ холбоог улам бүр өргөтгөж, энэ утгаараа дэлхий дахины глобальчлах үйл явцын эхлэлийг тавьсан үе байлаа. Монгол гүрэн XIII-XIV зуунд ийнхүү хүчирхэгжсэний нэгэн гол шалтгаан нь боловсролын асуудлыг чухалчлан үзэж, эрдэм мэдлэгтэй авъяас чадвартай, мэргэн, цэцэн хүмүүсээр төрийн алба хашуулахыг эрхэмлэн, нийгмийн дээд хэсгийнхний дотроос шилдэг хөвгүүд залуучуудыг сонгон авч, тэдэнд тухайлсан боловсрол эзэмшүүлэх бодлогыг төрөөс явуулж байсан байна.

Их эзэн богд Чингис хааны “... хүн хэдийгээр сэцэн төрөвч сургуулиас ангид мэргэн үл больюу, мэргэн сэцэн түшмэл улсын эрдэнэ” (1) хэмээсэн айлтгал нь Их монгол улсын төрөөс боловсролын асуудлыг эрхэмд үзэж байсны илрэл авай.

Энэ нь Монголд элит боловсрол үүсч хөгжих аятай боломжийг бүрдүүлжээ.

Өгүүлэн буй үеийн элит боловсролын тогтолцоо нь тухайлсан сургууль, хишигтний доторхи сургалт, ордны буюу гэрийн сургалт гэсэн гурван үндсэн хэлбэртэй байсан бололтой.

Өгэдэй хаан боловсролын талаарх эцгийнхээ бодлогыг тууштай үргэлжлүүлж байсан нь түүхийн баримтуудаас харагддаг. Тэрбээр суурин иргэншилтэй улс орныг удирдах залгамж халааг бэлтгэхийн чухлыг гярхай олж харан, 1233 онд Яньжин хотноо Их монгол улсын хөвгүүдийн сургуулийг байгуулан анхны монгол 18 сурагчийг тийш нь илгээн суралцуулж байжээ.(2)

Монголын Юань гүрний үед Хувилай хааны зарлигаар 1271 онд “Монгол улсын хөвгүүдийн сургуулийг” байгуулсан түүхтэй билээ. Их Монгол улсын хөвгүүдийн сургуулийн туршлага дээр тулгуурлан байгуулагдсан энэ сургууль сургалтаа монгол хэл дээр явуулдаг, төрийн хэрэг, хэл бичгийн өндөр боловсролтой, монгол төрийн албан хаагчдыг бэлтгэдэг монголын түүхэн дэх анхны дээд боловсролын байгууллага байсан төдийгүй, дорно дахинд тухайн үедээ хамгийн том агаад нэр нөлөө бүхий сургууль байлаа. Үнэхээр ч эл сургууль 1287 онд батлагдсан Юан улсын хөвгүүдийн дүрмэнд тодорхойлсон түүний зорилго, сургалтын агуулга, бүтэц зохион байгуулалт зэрэг нь дээрхийг гэрчлэх авай.(3) Нөгөө талаар XIII зуунд европ дахинаа “Их сургуулийн хувьсгал” гэж түүхэнд нэрлэгдсэн үйл явц өрнөж, анхны их сургуулиуд байгуулагдаж байлаа. Тухайн үедээ хөгжлийн төвшингөөр тэднээс дутахааргүй байсан Монгол гүрэн энэ үйл явцын гадна байсан гэхэд итгэхэд бэрхтэй гэдгийг сануулах юун. Гэвч энэхүү уламжлалыг хятадууд залган авсан бөгөөд харин Хар хорин муж буюу төрөлх монгол нутагт иргэний дээд боловсролын хөгжил тасалдаж эхэлсэн аж.

Монголд бурхны шашны гутгаар дэлгэрэлтийн үе, XYII зуунаас шашны боловсролын бүхэл бүтэн тогтолцоо бий болж. XYIII зуунаас Гавж аграмбын

дамжаа барих болсон түүхтэй билээ. Гандан хийд болон 1756 онд байгуулагдсан Дашчойнпэл, 1809 онд байгуулагдсан Зүүн дацан, 1910 онд байгуулагдсан Хойт дацан, 1807 онд байгуулагдсан Зүүн хүрээн дэх Жүд дацан зэрэг хүрээний их сургууль монгол даяар алдаршин, Халх, Ойрад, Буриад монголын шашны гүн ухааны сургалтын гол төв болж хувирсан бөлгөө. Дээр өгүүлсэн дацангуудад буддын гүн ухааны ном онолд зиндаа анги алгасалгүй суралцан Чойрын таван боть ном үзэж цол хүртдэг байжээ. Монголын IY богд Жавзандамба Лувсантүвдэнванчигийн их намтарт Тэнгэрийг тэтгэгчийн 46 дугаар он буюу 1781 онд Их хүрээнд гэвш Лувсандорж, Сономцэдэн гэдэг хоёр лам гавьж, Сайшаалт ерөөлтийн II он буюу 1807 онд Жамц, Содномдавга нарын хоёр лам мөн анхлан агримба цол хүртсэн тухай тэмдэглэгдэн үлджээ. 1937 оны байдлаар хүрээ хөдөөд Гавьж 2496, Агримба мяндагтан 392 байсан баримтын тухай бурхны шашны түүх судлаач лам Н.Дашзэвэг абугай өгүүлсэн байдаг. (4) Эдгээр нь шашны дээд боловсрол олгох байгууллага, тогтолцоо монголд байсныг гэрчилнэ.

Ийнхүү Монгол оронд иргэний хийгээд шашны боловсролын салбарт дээд боловсролын уламжлал байсан нь тодорхой байна. Дээр өгүүлсэнчлэн XIII зуунаас үүсэл нь тавигдсан иргэний дээд боловсролын сургуулийн уламжлал нэгэнтээ хэсэг хугацаанд тасалдсан авч, XX зууны эхэн үед монголчууд Манж чин улсын эрхшээлээс ангижирч, тэдний үндэсний ухамсар сэргэж, үндэсний сэргэн мандалтын үйл явц эхэлсэн тэр цаг үед дээд боловсрол эрхэлсэн сургалтын байгууллагын тухай асуудал дахин дэвшигдэн гарч ирсэн байна.

Энэ үеийн монгол төрийн зүтгэлтэн, бичгийн эрдэмтэн мэргэд сургууль боловсролын хөгжүүлэх хэргийг чухалчлан үзэж, ихэд анхаарч байлаа. "Манай улс өөрийн хойчийг залгамжлах хүчнийг бэлтгэхгүй бол мөсөн дээр барьсан гэр мэт үндэсгүй буюу хөгжин дээшлэхгүй хөлдсөн мэт болж буурна"(5) хэмээн манай төрийн зүтгэлтэн А.Амарын хэлсэн үгэнд дээр өгүүлсэн санаа тод илрэлээ олж байлаа.

Олноо өргөгдсөн Монгол улсын үед шинэ цагийн төрийн сургууль байгуулах анхны төсөл хийгдэж, бага дунд, дээд сургуулийн дүрэм хэмжээг боловсруулан гаргаж бага сургуулийг байгуулж байжээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараагаар иргэний бага сургуулийг шинээр үүсгэн хөгжүүлсэн нь хожмын хэрэгт нэн тустай болсон юм. Харин 1920-иод оноос ерөнхий боловсролын бүрэн бус дунд сургууль, тусгай мэргэжлийн сургуулиуд байгуулагдаж, тэдгээр нь европын ялангуяа зөвлөлтийн боловсролын агуулга, хэлбэр нөлөөгөөр өргөжин хөгжиж иржээ. 1940 онд манай улсын ерөнхий боловсролын анхны бүрэн дунд сургууль-нийслэлийн I арван жилийн сургуулийг байгуулсан байна.

Улс орны нийгэм эдийн засаг, соёлын цаашдын хөгжил нь дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх зайлшгүй хэрэгцээг шаардаж эхэлсэн агаад басхүү дээд сургуулийг байгуулах бэлтгэл ажил зарим талаар хийгдэж эхэлсэн нь уг асуудлыг шийдэх боломжийг бүрдүүлж байлаа.

1940 оны III сард хуралдсан МАХН-ын X их хурлын шийдвэрт улс орны аж ахуй, соёлын байгуулалт өргөжиж, мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээ улам нэмэгдэж байгааг харгалзан бүрэн дунд сургуулийн тоог олшруулахын хамт дээд сургууль байгуулах бэлтгэл хийхийг заасан байна.

Мөн оны XII сарын 6-ны өдөр Ардын сайд нарын Зөвлөл "Улаанбаатар хотноо улсын Университетийг байгуулах тухай" 45 дугаар (6) тогтоол гаргаж, Монгол Улсын Их Сургуулийг байгуулахаар шийдвэрлэжээ. Уг тогтоолын нэгдүгээр зүйлд "Тус улсын дотор анхдугаар дээд сургууль болох Улсын Университетийг зоотехник, сурган хүмүүжүүлэх, хүн эмнэлэгийн гурван анги

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

бүхийгээр Ардыг Гэгээрүүлэх Яамны харъяанд тус Улаанбаатар хотноо байгуулсугай” гээд 31 /41/ оны IX сараас нээхээр заасан байна. Улсын Университетийг нээх явдалд бэлтгэх зорилгоор Ардыг Гэгээрүүлэх Яаманд Тус Университетийн бэлтгэл хүчнийг дунд сургуулийн бэлтгэл анги бүхий хүмүүсээр байгуулж 31(41) оны III дугаар сарын 1- ний өдөр хүртлэх хугацаатайгаар I дүгээр сарын 15- наас хожимдуулалгүй хичээллүүлэх, университетийн бэлтгэл курсийн сурагчдыг мөнхүү курсийн хичээллэж буй үед албан ажлаас нь чөлөөлөлгүйгээр сургах, тэднийг орон сууц ба цалин хэрэглэлээр хангах, хичээлийн программуудыг бэлтгэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр заасан байна.

1940 онд их сургуулийн урьдчилсан бэлтгэл курсийг нэгдүгээр арван жилийн сургуулийн байранд 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр оройгоор хичээллүүлж эхэлжээ. Энд суралцагсад 1941 оны III сар болоход тус тусын албан ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд бэлтгэл курсийг бэлтгэл тасаг болгон өдрөөр хичээллүүлэх тухай Ардын сайд нарын зөвлөлийн тогтоол 1941 оны XII сард гарсан байна. Уг тогтоолд: “Улсын Университетийн бэлтгэл курсийг 1942 оны I сарын 1-ээс дээд сургуулийн бэлтгэл тасаг болгон 1942 оны IX сарын 1 хүртэл хичээллүүлэхийг заагаад хичээлийг өдрөөр хичээллүүлэх ба зохих тооны сурагчдаар 1941 оны XII сарын 12-наас хангах, бэлтгэл тасгийн сурагчдын тоог 90 хүнээр тогтох, түүнд элсүүлэх сурагчдын асуудлыг Ардыг Гэгээрүүлэх Яам, Эрүүлийг Хамгаалах Яам, Мал Тариалангийн Яамуудад даалгасан байна(7)”

Энэ тогтоолын биелэлтийн талаар 1942 оны II сарын 16-ны өдөр Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд Машлайгаас, Чойбалсан болон Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлд хандсан илтгэлд: “Энэ завсар дээд сургуульд суралцуулахаар 40 хүнийг элсүүлсэн бөгөөд тэдгээрээс дунд сургуулийн долдугаар ангийн программаар шалгалт авахад 4 хүн дунд, бусад нь муу байгаа ба тэдгээр сурагчид суралцах сонирхолгүйн дээр орос хэл мэдэх хүн цөөн байгааг дурьдаад , Орос хэл мэдэхийг нь нэг анги болгоод үл мэдэхийг нь 10 дугаар ангийн программыг үзүүлж дээд сургуульд орж чадахыг нь түүвэрлэн авъя (8) гэж хүссэн байна.

1942 оны III сарын 3-нд БНМАУ-ын Ардыг Гэгээрүүлэх Яамны сайдаас гаргасан 37 дугаар тоот тушаалд: “ Улсын дээд сургуулийн бэлтгэл тасгийг энэ гуравдугаар сарын гуравны өдөр нээн хичээлийг эхлүүлсүгэй. Энэ өдрийг тус сургуулийн түүхт өдөр болгон дурссугай”(9) гэжээ. Ийнхүү энэ удаад МУИС-ийн байгуулагдсан өдрийг 1942 оны III сарын 3-ны өдөр гэж үзэхээр сайдын тушаалд заасан нь сонирхол татсан зүйл билээ.

Сургуулийг нээн хичээллүүлэхэд орон байрны асуудал чухлаар тавигдаж байсан нөхцөл байдлыг харгалзан тухайн үед холбооны сургуулийн байшинг шилжүүлэн өгөх болжээ. Энэ тухай 1942 оны VII сарын 20-нд Ардыг Гэгээрүүлэх Яамны дэд сайд Нацагаас Намын Төв Хороонд гаргасан илтгэх хуудсанд: “1942 оны IX сарын 1-нээс дээд сургуулийн хичээлийн байшинд холбоо хорооны харъяа холбооны сургуулийн байшин ба түүний зарим тасалгаануудыг дээд сургуулийн хичээллэх корпус байр болгон хэрэглэж болно. Есдүгээр сараас эхлэх дээд сургуульд чухал хэрэглэгдэх бүх байр сууцаар хангагдах болно(10).” гэсэн байна.

Энэ үндсэн дээр 1942 оны IX сарын 15-нд Их Сургуулийн орлогч захирал Чимэддамба , Холбооны техникумын захирал Содномгомбо нарын гарын үсэг зурсан актаар Монгол Улсын Их Сургуулийн хичээлийн байр болгон түр шилжүүлжээ.(11)

Ардын Сайд нарын Зөвлөлийн “Улсын дээд сургуулийн санхүүжүүлэлтийн тухай” 15 дугаар хурлын тогтоолоор (1942.II.16) Мал тариалангийн яамнаас

Монголын шаши, соёл, сэтгэлгээний түүх

158980 төгрөг, Эрүүлийг хамгаалах яамнаас 87000 төгрөг, Ардыг гэгээрүүлэх яамнаас 191908 төгрөг нийтдээ эдгээр гурван яамнаас 445388 төгрөг гаргахаар баталжээ.(12) Ийнхүү хөрөнгө мөнгөний асуудлыг ч шийдэж байсан байна.

Их сургуулийн хичээлийг 1941 онд эхлүүлэхээр төлөвлөж байсан боловч энэ хугацаандаа амжаагүй юм.

Үүнийг тухайн үедээ сурагчдийн элсэлт бүрдээгүй, элссэн сурагчид нь мэдлэг боловсрол нэн дорой, сургуулийн барилгын асуудал шийдэгдээгүй. (есдүгээр сарын байдлаар), санхүүжилт бүрдээгүй. (мөн үеийн байдлаар) зэрэг шалтгаануудын улмаас тус дээд сургууль төлөвлөгдсөн ёсоороо хугацаандаа нээгдэж чадаагүй гэж тайлбарласн байна. Дээр товч өгүүлсэн эдгээр шалтгаануудыг арилгах арга хэмжээ авчээ.

Ингээд 1942 оны 10 дугаар сарын 5-ны өдөр орчин үеийн Монголын түүхэн дэх анхны дээд Сургуулийг нээх ёслолын хурал Улаанбаатар хотноо В.И.Лениний нэрэмжит клубт болж өнгөрлөө. Тус хурлыг нээж Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд Машлай үг хэлсэн ба ба тус хурлын тэргүүлэгчдийг сонгох, улсын университетийн нээлтийн тухай илтгэлийг хичээлийн эрхлэгч Дашжамц тавьсан байна. Мөн Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Цэдэнбалаас Дээд Сургуульд суралцагсдын суралцах зорилгын тухай илтгэл, ерөнхий сайд Чойбалсангаас хүндэт сануулга, Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс ирүүлсэн баярын утас тус тус явагдаад хурлын хэрэг төгссөн (13) гэж тухайн үеийн баримтанд өгүүлжээ.

Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс ирүүлсэн уг цахилгаан утсанд: "БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс, Монгол Улсын Их Сургуулийг нээсэнд баяр хүргэе" гээд шинжлэх ухаан ба үндэсний соёлыг хөгжүүлэхэд их сургуулийн үүргийг дурьдаад Шинжлэх Ухааны Хүрээлэн, Монгол Улсын Их Сургууль хоёр нэг зорилго хүсэлтэй ажиллана гэснээс гадна их сургуульд суралцагсад нь онц сайн суралцаж Монгол улсын ойрын ба алсын ирээдүйд хэргээ үзүүлэх хэрэгтэй гэжээ. (14)

Ингээд маргааш нь буюу 1942 оны X сарын 6-ний өглөөнөөс Монгол Улсын Их Сургуулийн анхны хичээлийн жилийн эхний хичээл нь хуучин холбооны техникум байрлаж байсан жижиг байшинд эхэлжээ. Энэ өдөр анх 95 оюутан, 11 багш хичээллэж байсан байна(15). Мөн оройн эчнээ ангиудад нийт 146 оюутан сурагчид элсэн орсноос 14 нь зөвлөлтийн харъяат нар байсан юм. Үүнээс жинхэнэ факультетэд 89 оюутан, бэлтгэл курсэд 57 сурагчид байсан ба долдугаар сарын нэгний байдлаар бүгд 160 оюутан сурагчид физик тооны, хүн эмнэлгийн, зоотехник (мал эмнэлэг)-ын гурван факультеттайгаар үйл ажиллагаа эхэлжээ.

Эдгээрээс гадна зургаан тооны Монгол оюутнуудыг өөр мэргэжлийн хичээлүүдэд тусгай программаар суралцуулж байжээ. Үүнд: Химийн ухааны мэргэжилд дөрвөн хүн, амьтны аймгийг шинжлэх мэргэжилд нэг хүн, мал аж ахуйн мэргэжилд нэг хүн болох бөгөөд эдгээр хүмүүсийг сургах хугацааг гурван жил хагасаар тогтоосон ба бусад жинхэнэ ангиудад суралцах хугацаа нь таван жил болно.(16) гэж заасан байна.

Ийнхүү улсын анхны их сургууль үйл ажилагаагаа амжилттай эхэлсэн ба улмаар 1942-1943 оны хичээлийн жил буюу их сургуулийн анхны хичээлийн жилд оюутан сурагчдаа амжилттай сургасан билээ.

Монгол Улсын Их Сургуульд одоо нэн түрүүнд шийдэх асуудал сургуулийн зориулалтын барилга барих явдал байсан ба 1944 оны I сарын 4-ний өдрийн 12 цагт Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайд Маршал Чойбалсан оролцон, Улсын анхдугаар их сургуулийн барилгын анхны суурийг тавьжээ.(17)

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Монгол улсын их сургуулийн төв байр 1943 онд эхний ээлж нь ашиглалтанд ороод 1946 оны арван сарын 21-нд бүрэн баригдаж дууссан байна.

Их сургууль нь 1946 оны анхныхаа төгсөлтийг хийсэн ба үүнд мал эмнэлгийн ангийг 16 хүн, хүн эмнэлгийн ангийг 1 хүн, физик тооны ангийн 18 хүн нийт 35 мэргэжилтэн төгсөн гарчээ.

Их сургуульд багшлах боловсон хүчнийг бэлтгэхдээ эхний жилүүдэд Зөвлөлт Холбоот Улс мэргэжилтнүүдийг урин ирүүлдэг байснаас гадна их сургуулийн сургалтын төлөвлөгөө, лабораторийг зохион байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэж Монгол нөхдийг дагалдуулан сургаж байсан ба Зөвлөлт Холбоот Улсын их дээд сургуульд суралцуулан төгсгөх ба тэнд эрдмийн зэрэг хамгаалж мэргэжил дээшлүүлж байв.

Сургалт шинжилгээний гол гол лабораториудыг Зөвлөлт Холбоот Улсын тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож байв.

1947 оны хоёрдугаар сарын нэгний өдөр Намын Төв Хорооны тавдугаар хурлын тогтоолоор Ардыг Гэгээрүүлэх Яамны мэдэлд байсан Монгол Улсын Их Сургуулийг Сайд Нарын Зөвлөлийн мэдэлд шилжүүлсэн ба философич, түүхч, эдийн засагч зэрэг мэргэжлийн боловсон хүчний шаардлага их байгааг харгалзан Монгол улсын их сургуульд Нийгмийн ухааны факультет байгуулах шийдвэр гарчээ. Уг факультетийг марксизм-ленинизмийн үндэс ба философи, эдийн засаг, түүхийн гэсэн гурван тэнхимтэйгээр 1947 оны IX сард байгуулжээ. Мөн энэ оноос Монгол улсын их сургуулийг таван жилийн төлөвлөгөөтэйгөөр хөгжүүлэх ажил зохион явуулсан байна.

Ийнхүү манай орчин цагийн ууган их сургууль өөрийн сургалт эрдэм шинжилгээний ажлын гараагаа эхэлсэн тэр цаг үеэс хойш нэгэн жарныг ардаа орхиж байна.

Иш татсан эх сурвалж, ном зохиол, бүтээлүүд

1. Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг, 2-р дэвтэр УБ., 1992. 32 дахь тал
2. Д.Наран. Монголын төр ёсны болвсролын түүх УБ., 2001. 37 дахь тал
3. Мөн тэнд 87-94 дэх тал
4. Н. Дашзэвэг. "Шашинт номын дээд цол – гавьж, агримба хүртэхийн учир" Дорно, өрнө. 1991, №3, 35 дахь тал
5. УТА. Ф-339, Т-2, хн 335, 46 дахь тал
6. ТТА. Ф-1, Т-2, хн 768, 278-280 дахь тал
7. ТТА. Ф-6, Т-2, хн 578 140-142 дэхь тал
8. ТТА. Ф-6, Т-2, хн 578 147-148 дахь тал
9. ТТА. Ф-6. хн 578 136 дахь тал
10. Мөн тэнд 10-12 дахь тал
11. Г.Загд. Монгол улсын их сургуулийн түүхээс. УБ., 1965. 18 дахь тал
12. Мөн тэнд 144-145 дахь тал
13. ТТА. Ф-334. Т-1. хн 3. 3 дахь тал
14. Мөн тэнд
15. ТТА. Ф-334. Т-1 хн 162 5 дахь тал
16. ТТА. Ф-6. Т-2. хн 637. 12-13 дахь тал
17. ТТА. Ф-6. Т-2 хн 337. 148 дахь тал